

**ХЯНАЛТЫН ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЛИЙН АНГИЛАЛ, ТӨРӨЛ, ТЭЭВЭРЛЭЛТ ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЭЛД СУУРИЛУУЛАХ ТАХОГРАФИД ТАВИГДАХ ШААРДЛАГА,
ТАХОГРАФИЙГ АШИГЛАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ХЯНАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмаар хяналтын төхөөрөмж(цаашид “тахограф” гэх) суурилуулах шаардлагатай тээврийн хэрэгслийг тодорхойлох, тахографт тавих шаардлага, тахографыг ашиглах, үйлчилгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

**Хоёр. Тахограф суурилуулах шаардлагатай
тээврийн хэрэгсэл**

2.1. Улс, хот, аймаг хооронд тээвэрлэлтэд ажиллаж буй бүх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин болон нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний автобусанд тахографыг суурилуулна.

2.2. Дараах тээврийн хэрэгслүүдэд тахограф заавал суурилуулах шаардлагагүй. Үүнд:

2.2.1. Бетон зуурмагын шахуургын машин, бетон зуурагч машин, асфальт түгээгч, автокран, эмнэлгийн түргэн тусламж, техникийн тусламжийн чирэгч, галын машин, троллейбус, онцгой байдал болон цагдаагийн албан машин;

2.2.2. Цэрэг, батлан хамгаалах байгууллагад бүртгэлтэй автомашин;

2.2.3. Аж ахуйн нэгж, байгууллагын доторх нутаг дэвсгэрт тээвэрлэлт хийх, нийтийн хэрэгцээний авто зам руу гарахгүй автомашин;

2.2.4. Ачаа, зорчигч тээвэрлэхэд зориулагдаагүй тээврийн хэрэгсэл;

2.2.5. Арилжааны зорилгоор ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэдэггүй зөвхөн сургалтын үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хэрэгсэл;

2.2.6. Харицаа холбооны чиглэлээр тусгай үүрэг гүйцэтгэж буй автомашин.

Гурав. Тахографид тавих шаардлага

3.1. Тээврийн хэрэгсэлд суурилуулах тахограф нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурд, зорчсон замнал, жолоочийн ажил, амралтын горим зэрэг хөдөлгөөний талаарх мэдээллийг ямар нэгэн засваргүйгээр тасралтгүй бүртгэх шаардлагыг хангасан байна. Эдгээр шаардлагыг тахограф болон тэдгээрийн эд ангиудыг үйлдвэрлэх, нийлүүлэх, засварлах үйл ажиллагаа эрхлэгч нар дагаж мөрдөнө.

3.2. Тахограф нь техникийн хувьд ISO MNS :2022 стандартын шаардлагыг хангасан байна.

3.3. Тахограф нь ISO MNS :2022 стандартын дагуу дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

3.3.1. Тахографын карт;

3.3.2. Хөдөлгөөн мэдрэгч;

3.3.3. Хиймэл дагуулын GPS системээс мэдээлэл хүлээн авах антен;

3.3.4. GSM/GPRS системээс дохио хүлээн авах, дамжуулах антен (хэрэв эдгээр холбооны модулийг тахографид оруулсан бол);

3.3.5. Тахографын эд ангиудыг холбох, тэдгээрийг тээврийн хэрэгсэлд суурилуулахад зориулагдсан холбох багц хэрэгслүүд;

3.4. Тахограф нь нээхээс сэргийлсэн битүүмжлэгдсэн хайрцагтай байх ба дараах эд ангийг агуулсан байна. Үүнд:

3.4.1. Өгөгдөл боловсруулах төхөөрөмж;

3.4.2. Цахим мэдээлэл хадгалагч дээр бичигдсэн өгөгдөл боловсруулах төхөөрөмжид зориулагдсан програм хангамж;

3.4.3. Засваргүйгээр бүртгэх өгөгдлийг заавал бүртгэх шаардлагагүй мэдээллийг хадгалах санах ойн блок;

3.4.4. Холбооны модуль (холбооны модулийг тахографид оруулах шаардлагатай эсэхийг тухай үйлдвэрлэгч тодорхойлно);

3.4.5. Хурдатгалын мэдрэгч (суурилуулах шаардлагатай эсэхийг үйлдвэрлэгч тодорхойлно)

3.4.7. Мэдээлэл үзүүлэх дэлгэц;

3.4.8. Карт оруулах хоёр ширхэг оролт;

3.4.9. Хэвлэх төхөөрөмж;

3.4.10. Ослын үеийн товчлуур;

3.4.11. Харааны болон дуут анхааруулах хэрэгсэл;

3.4.12. Засвар үйлчилгээний функц гүйцэтгэх болон өгөгдөл татаж авах (байршуулах) оролт;

3.4.13. Хиймэл дагуулын дохиог хүлээн авах антенныг холбох оролт;

3.4.14. Хэрэв тахографид GSM/GPRS холбооны модулийг дэмждэг бол эдгээр модулиас дохио хүлээн авах антенныг холбох оролт;

3.4.15. SIM картанд зориулсан үүр (төхөөрөмжид SIM карт суурилуулах шаардлагатай эсэхийг үйлдвэрлэгч тодорхойлно);

3.4.16. Тахограф мэдээлэл оруулах хэрэгсэл (товчлуур);

3.5. Тахограф нь баталгаажсан цахим гарын үсгийн үндсэн дээр тахографт засваргүйгээр бүртгэгдсэн мэдээллийг хадгалах болон найдвартай байдлыг хангах, түүнчлэн төхөөрөмжид бүртгэгдсэн мэдээллийг шалгасны үр дүнгээр төхөөрөмжийн тохиргоо алдагдсан, эсхүл хуурамчаар бүртгэсэн мэдээллийг баталгаатай илрүүлэх ёстой.

3.6. Идэвхжүүлэх үйл ажиллагааны дараа тахограф нь дараах горимд ажиллана. Үүнд:

3.6.1. “Ажлын” – жолоочийн картаар идэвжиж, мэдээллийг тахографид бүртгэх горим;

3.6.2. “Хяналтын” – хяналтын албан хаагчийн картаар идэвхиж, жолоочийн үйл ажиллагааг хянах горим;

3.6.3. “Өгөгдлийн тохируулга хийх” – засварын картаар идэвхиж, тахографын өгөгдөлд тохируулга хийх горим;

3.6.4. “Аж ахуйн нэгж” – аж ахуйн нэгжийн картаар идэвхиж, жолоочийн үйл ажиллагаа болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний талаарх мэдээллийг шалгах горим;

Дөрөв. Тахографын функцууд болон түүний бүтцэд тавигдах шаардлагууд

4.1. Тахограф нь карттай ажиллахдаа дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- 1) Картыг төхөөрөмжид хийсэн болон гаргасныг бүртгэх;
- 2) картын төрлийг тодорхойлох ба хүчинтэй хугацааг нь хянах;
- 3) картын төрлөөс хамааран тахографын функц болон өгөгдлүүдэд нэвтрэлтийг зааглах;
- 4) шифрлэх (криптографик) хэрэгслүүдийг ашиглан картыг харилцан таниулах;
- 5) мэдээллийг картын санах ойд засваргүй хэлбэрээр бичих;
- 6) картыг үүрэнд хийхэд түүнийг механикаар түгжих;
- 7) картыг зөвхөн тээврийн хэрэгсэл зогссон үед, жолоочийн үйл ажиллагааны талаарх өгөгдлүүдийг тахографаас картын санах ой руу бичигдсэний дараагаар гаргах үүрэгтэй.

4.2. Тахограф нь ажлын горимд дараах үүргүүдийг гүйцэтгэнэ:

1) Хиймэл дагуулын системээс авах өгөгдлүүд байгаа нөхцөлд (цагт 20-180 км/ц хэмжилтийн хүрээнд) нарийвчлалын геометр бууралтын хүчин зүйлийн үзүүлэлт $PDOP^8 \leq 3$ (магадлалын түвшин 0.95-аар) цагт 2 километрээс ихгүй алдаатайгаар тээврийн хэрэгслийн хурдыг тодорхойлно;

2) хөдөлж буй тээврийн хэрэгслийн хурдын үзүүлэлтийг засваргүй хэлбэрээр секундэд нэгээс цөөнгүй удаа бүртгэнэ;

3) Хиймэл дагуулын системээс авах өгөгдлүүд байхгүй нөхцөлд (цагт 20-180 км/ц хэмжилтийн хүрээнд) хөдөлгөөн мэдрэгчээс ирэх импульсууд дээр үндэслэн (магадлалын түвшин 0.95-аар) цагт 2 километрээс ихгүй хэмжилтийн алдаатайгаар тээврийн хэрэгслийн хурдыг тодорхойлно;

4) тээврийн хэрэгслийн хурд цагт 1.8 километрээс дээш байхад, эсхүл 5 секундээс багагүй хугацаанд хөдөлгөөн мэдрэгчийн нэгээс цөөнгүй импульс хүлээж авсан тохиолдолд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тооцон бүртгэнэ;

5) Хиймэл дагуулын системээс хүлээн авсан өгөгдлүүдэд үндэслэн тээврийн хэрэгслийн хурд, туулсан зам, хөдөлгөөн мэдрэгчийн импульсын тоо (давтамж) хоорондын давхцлын коэффициентийг автоматаар тооцоолон тодруулна;

6) тухайн давхцлын коэффициент 10 %-иас дээш өөрчлөгдсөн тохиолдолд тээврийн хэрэгслийн хурд, туулсан зам, хөдөлгөөн мэдрэгчийн дохионы тоо (давтамж) хоорондын нийцлийн коэффициентийг автоматаар тодотгосон баримтыг бүртгэнэ;

7) Хиймэл дагуулын системээс авах өгөгдлүүд байгаа нөхцөлд координатын тэнхлэгийн дагуу (өргөргийн 90°, уртрагийн 180° хэмжилтийн хүрээнд) нарийвчлалын геометр бууралтын хүчин зүйлийн үзүүлэлт PDOP \leq 3 (магадлалын түвшин 0.95-аар) 3 метрээс ихгүй алдаатайгаар тээврийн хэрэгслийн байршлын координатуудыг тодорхойлох ба координатын тэнхлэгийн дагуу (өргөргийн 90°, уртрагийн 180° хэмжилтийн хүрээнд) нарийвчлалын геометр бууралтын хүчин зүйлийн үзүүлэлт PDOP \leq 3 (магадлалын түвшин 0.95-аар) 15 метрээс ихгүй эргэлзээтэйгээр тээврийн хэрэгслийн байршлын координатуудыг тодорхойлно;

8) хөдөлж буй тээврийн хэрэгслийн байршлын координатуудын үзүүлэлтийг засваргүй хэлбэрээр секундэд нэгээс цөөнгүй удаа бүртгэнэ;

9) тээврийн хэрэгслийн хөдөлгөөний явцад туулсан замын (1-ээс 9 999 999.9 километрын хэмжилтийн хүрээнд) 1000 метреес багагүй хэсгийн (магадлалын түвшин 0.95-аар) 1%-иас илүүгүй хэмжилтийн алдаатайгаар тээврийн хэрэгслийн туулсан замыг (гүйлт) тодорхойлох ба үүнийг секундэд нэгээс цөөнгүй удаа бүртгэнэ

10) тээврийн хэрэгслийн хөдөлгөөний явцад тээврийн хэрэгслийн туулсан нийт замд (гүйлт) тохирох өгөгдлүүдийг секундэд нэгээс цөөнгүй удаа бүртгэнэ;

11) Хиймэл дагуулын системийн дохиогоор ажиллахдаа (0-ээс 3600 секундын хэмжилтийн хүрээнд) 2 секундээс илүүгүй (магадлалын түвшин 0.95-аар) алдаатайгаар дотоод цагийн алхмыг UTC орон нутгийн цагийн алхамтай давхцуулна;

12) цагийн завсарлагын хэмжилтийг (60-аас 86400 секундын хэмжилтийн хүрээнд) (магадлалын түвшин 0.95-аар) 4 секундээс илүүгүй алдаатайгаар хийнэ;

4.3. Тахограф нь дараах ажиллагааг хангана:

1) цаг, хугацаа, хуанлийн огноо болон тээврийн хэрэгслийн байршлын координатуудын талаарх мэдээллүүдийг (хиймэл дагуулын системээс хүлээж авах дохио байгаа тохиолдолд) хүлээж авах ба засваргүй хэлбэрээр бүртгэж авна;

2) суурин төхөөрөмжөөс, картаас тээврийн хэрэгслийн туулсан орон нутгийн UTC (SU) цагийн хугацаа болоод нийт замын (гүйлт) заалтуудыг дэлгэц заалтуудыг минут болон километр тус бүрээр салган дэлгэц дээр харуулах мөн/эсхүл хэвлэж гаргах, мөн/эсхүл өгөгдлүүдийг суурин төхөөрөмжөөс хуулах;

3) цагийн бүсийг харгалзан дэлгэц дээр гаргах цагийн заалтуудыг орон нутгийн цагт тааруулж өөрчлөх боломжтой байна;

4) өдөрт 2 секундээс дээш уншилтын зөрүүтэй тохиолдолд тахогарафын цагийн заалтыг автоматаар тохируулах (хиймэл дагуулын системээс хүлээж авах дохио байгаа тохиолдолд);

5) тэжээлийн гадаад эх үүсвэргүй нөхцөлд 12 сараас багагүй хугацаанд цагийг бодит цагийн горимд ажиллуулах;

6) дараах хугацааны нөхцлүүдийг эс тооцвол, хиймэл дагуулын системээс хүлээж авах өгөгдлүүдийг үндэслэн орон нутгийн UTC (SU) цагийн, тээврийн хэрэгслийн

хурдны болоод байршлын координатуудыг дор хаяж 1 секундэд нэг удаа засваргүйгээр бүртгэнэ:

- суурин төхөөрөмжид цахилгаан тэжээл өгөгдөхгүй байгаа;
- тээврийн хэрэгсэл хөдөлгөөнгүй байх болон Шаардлагуудын дагуу тахографт бүртгэгдэх ямарваа үйл явдал өрнөөгүй байх.

4.4. Тахограф нь ажлын горимд дараах ажиллагааг хангана:

1) жолоочийн үйл ажиллагааны дараах горимуудыг бүртгэнэ: “жолоодлого”, “ажил”, “бэлэн байдал”, эсхүл “завсарлага/амралт”;

2) ажлын үүрэг нь болох тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн ажлын цагийг, мөн жолоодлогын цагийг (цаашид – “тээврийн хэрэгсэл жолоодлогын хугацаа” гэх), ажлын үүрэг нь болох тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн амралтын хугацааг, түүнчлэн жолоодлогын цаг болон амралтын цагийн нийлбэрүүдийг тооцоолж бүртгэнэ;

3) үндсэн, эсхүл ээлжийн жолооч дараах горимыг гар аргаар сонгох: “ажил”, “бэлэн байдал”, эсхүл “завсарлага/амралт”;

4) хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийг жолоодож байгаа жолоочийн “жолоодлого” горимыг автоматаар, ээлжийн жолоочийн “бэлэн байдал” горимыг автоматаар бүртгэнэ;

5) тээврийн хэрэгслийг 1 жолооч жолоодож яваа тохиолдолд тээврийн хэрэгслийг зогсох үед “ажил” горимыг автоматаар бүртгэнэ;

6) тээврийн хэрэгсэл зогссоноор “ажил” горимд автоматаар шилжээд 120 секунд өнгөрсний дараа тээврийн хэрэгслийн жолоочийн үйл ажиллагааны горим өөрчлөгдсөнийг бүртгэнэ;

7) жолоочийн үйл ажиллагааны горим өөрчлөгдсөн талаарх өгөгдлүүдийг засваргүй хэлбэрээр бүртгэнэ.

5. Тахограф нь хоёр жолоочийн хүчинтэй картыг хийсэн тохиолдолд жолоодлогын байдлыг “баг” гэж бүртгэх, бусад бүх тохиолдолд жолоодлогын байдлыг “нэг жолоочтой” гэж бүртгэнэ.

4.5. Тахограф нь өгөгдөл оруулахад дараах шаардлагуудыг хангана:

1) тээврийн хэрэгслийн жолоодлогын хугацаа эхлэх болон дуусах газруудын координатуудыг автоматаар тодорхойлох болон бүртгэх;

2) жолоочийн картыг хийсний дараа мэдээллийг гар аргаар оруулахыг автоматаар санал болгох, мөн:

- уг картыг хамгийн сүүлд төхөөрөмжөөс гаргаж авсан огноо ба цагийн талаарх мэдээллийг, улмаар уг картыг төхөөрөмжид хийсэн нь тээврийн хэрэгслийн тухайн үеийн жолоодлогын үргэлжлэл гэж тооцох талаар асуулгыг дэлгэц дээр гаргах;
- огноо болон эхлэх ба дуусах цагуудыг заасан (“ажил”, “бэлэн байдал” эсхүл “завсарлага/амралт”) үйл ажиллагааны горимын талаарх өгөгдлүүдийг оруулах асуулгыг дэлгэц дээр гаргах;

3) мэдээлэл оруулахыг хүлээх горим ассан тухай мэдээллийг дэлгэц дээр гаргах, мэдээлэл оруулахыг нэг минутын хугацаанд хүлээх ба 30 секунд өнгөрмөгц дуут дохио өгөх;

4) тахографын шаардсан мэдээллийг нэг минутын хугацаанд оруулж эхлээгүй нөхцөлд жолооч өгөгдлүүдийг гар аргаар оруулаагүй гэж бүртгэнэ;

5) “ажил”, “бэлэн байдал”, “завсарлага/амралт” гэсэн горимуудын талаарх өгөгдлүүдийг дараах алгоритмуудын дагуу гараар оруулна:

- хэрэв жолоочийн картыг эзэмшигч “тээврийн хэрэгслийг жолоодох хугацаа эхлэх газрын нэршил” гэсэн асуулгад баталсан хариулт оруулвал тухайн картыг тахографт оруулаагүй байсан хугацааны үйл ажиллагаануудын өгөгдлүүдийг он цагийн дарааллаар гараар оруулах санал дэлгэц дээр гарна;
- хэрэв гар аргаар оруулсан үйл ажиллагааны дуусах цаг нь картыг оруулсан цагтай тохирч байгаа тохиолдолд гараар оруулах явц үүгээр дуусна;
- хэрэв жолоочийн картыг эзэмшигч “тээврийн хэрэгслийг жолоодох хугацаа эхлэх газрын нэршил” гэсэн асуулгад татгалзсан хариулт оруулвал тухайн картыг гаргаснаас хойш тээврийн хэрэгслийг жолоодож дууссан хүртэлх хугацааны үйл ажиллагаануудын өгөгдлүүдийг он цагийн дарааллаар гараар оруулах санал дэлгэц дээр гарна;
- хэрэв жолоочийн картыг эзэмшигч тээврийн хэрэгсэл жолоодох өмнөх хугацаа хэзээ дууссаныг заагаагүйг бөгөөд дуусах хугацаа нь картыг төхөөрөмжид хийх цагтай давхцсан үйл ажиллагааны өгөгдлүүдийг гараар оруулвал тахограф нь тээврийн хэрэгслийг жолоодох хугацааг эхний “амралтын” (эсхүл “өгөгдөл байхгүй” үе) хугацааны эхэнд дууссан гэж бүртгэнэ;
- хэрэв тээврийн хэрэгсэл жолоодох хугацааны эхлэх цаг картыг төхөөрөмжид хийсэн цагтай давхцаж байвал тээврийн хэрэгсэл жолоодох тухайн явж буй хугацааны эхлэх цагийг оруулах асуулга дэлгэц дээр гарна;
- хэрэв тээврийн хэрэгсэл жолоодох хугацааны эхлэх цаг картыг оруулсан цагаас зөрж байвал тээврийн хэрэгсэл жолоодох тухайн явж буй хугацаа эхэлснээс картыг оруулах хүртэлх хугацааны үйл ажиллагаануудын өгөгдлүүдийг он цагийн дарааллаар гараар оруулах санал дэлгэц дээр гарна;

4.6. Тахограф нь дараах ажиллагааг хангана:

1) дараах нөхцөл байдлуудын талаарх мэдээллийг засваргүй хэлбэрээр гараар оруулах ба бүртгэх:

“үл хамаарах” – тээврийн хэрэгслийн хөдөлгөөн картгүйгээр явагдах, эсхүл хяналтын карт болон аж ахуйн нэгжийн картайгаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөн явагдвал;

“усан гатлага/галт тэргээр тээвэрлэгдэх”;

2) “үл хамаарах” нөхцөлийг оруулсан тохиолдолд «усан гатлага/галт тэргээр тээвэрлэгдэх» нөхцөлийн мэдээллийг оруулах боломжгүй;

3) “үл хамаарах” байдлын мэдээллийн бүртгэлийг жолоочийн картыг төхөөрөмжид хийхэд автоматаар цуцална.

4.7. Тахограф нь ажлын “аж ахуйн нэгж” горимд блок тавих үед тахографын мэдээлэл болон жолоочийн картын мэдээлэлд нэвтрэх эрх олгогдоогүй этгээдэд нэвтрэх боломжийг олгохгүй бөгөөд:

1) картыг төхөөрөмжид хийж тээврийн хэрэгсэл эзэмшигчийг баталгаажуулах үед хаалтыг «on» («on»-асаасан) байрлалд эсхүл «off» («off»-унтраасан) байрлалд тохируулах;

2) хаалт тавьсан огноо, цаг болон хаалт авсан огноо ба цагийг бүртгэх;

3) тээврийн хэрэгсэл эзэмшигч хаалт тавих үед өмнөх тавьсан хаалт нь авагдаагүй байгаа бөгөөд “он” (асаасан) байрлалд байгаа тухай мэдээллийг дэлгэцэнд гаргах.

4.8. Тахограф нь дараах мэдээллүүдийг дэлгэцэнд гаргана:

1) анхааруулах;

- тээврийн хэрэгслийн тогтоосон хөдөлгөөний хурд хэтэрсэн;
- хөдөлгөөний хурдын өгөгдлүүдийг дамжуулах дарааллын алдаа, эсхүл хөдөлгөөний мэдрэгчээс ирэх болон хиймэл дагуулын системээс ирж буй өгөгдлүүд дээр тулгуурлан тээврийн хэрэгслийн бүртгэгдэж буй тухайн үеийн хурдын өгөгдлүүдийн тохиргоо алдагдсан;
- хүчингүй карт төхөөрөмжид хийсэн;
- картгүйгээр жолоо барьсан;

2) тахографын санах ойгоос дараах өгөгдлүүдийг:

- жолооч нарын үйл ажиллагааны горимын (“ажил”, “бэлэн байдал” эсхүл “завсарлага/амралт”);
- хурд хэтрүүлэлтийн;
- тээврийн хэрэгслийн туулсан замын;
- үйл явдал ба гэмтлүүдийн;

3) хамгаалагдсан архив болон картаас гадны төхөөрөмжүүд рүү өгөгдөл хуулсан талаарх мэдээллийг;

4) “үндсэн жолооч” болон “ээлжийн жолооч”-ийн картуудыг унших төхөөрөмжид дараах картуудыг нэгэн зэрэг хийх тохиолдолд картуудын үл зохицолгоог:

- жолоочийн карт засвар үйлчилгээний карттай;
- хяналтын карт засвар үйлчилгээний карттай эсхүл аж ахуйн нэгжийн карттай эсхүл өөр хянагчийн карттай;
- засвар үйлчилгээний карт жолоочийн карттай эсхүл хяналтын карттай эсхүл аж ахуйн нэгжийн карттай эсхүл өөр засвар үйлчилгээний карттай;
- аж ахуйн нэгжийн карт хяналтын ийн карттай эсхүл засвар үйлчилгээний карттай эсхүл өөр аж ахуйн нэгжийн карттай.

4.9. Тахограф нь үйл явдал болон гэмтлийг бүртгэхдээ:

1) хүчингүй карт, эсхүл хугацаа нь дууссан карт оруулсан мэдээллийг засваргүй хэлбэрээр бүртгэнэ;

2) жолоочийн картаас уншсан тухайн огноо ба картыг төхөөрөмжид хийсэн цаг картыг хамгийн сүүлд төхөөрөмжөөс гаргасан огноо, цагаас урьтаж байгаа тохиолдолд “цаг зөрүүтэй” талаарх мэдээллийг бүртгэнэ;

3) картгүйгээр жолоо барьсан тухай мэдээллийг дараах тохиолдолд бүртгэнэ:

- үндсэн жолоочийн карт уншигч төхөөрөмжид тахографын картыг хийгээгүй, эсхүл хийсэн карт хүчингүй байна;
- үндсэн жолоочийн уншигч картын төхөөрөмжид хүчинтэй жолоочийн картыг хийсэн ба ээлжийн жолоочийн карт уншигч төхөөрөмжид хяналтын эсхүл засвар үйлчилгээний, эсхүл аж ахуйн нэгжийн хүчинтэй картыг хийсэн байна;
- үндсэн жолоочийн карт уншигч төхөөрөмжид хүчинтэй засвар үйлчилгээний картыг хийсэн ба ээлжийн жолоочийн карт уншигч төхөөрөмжид хүчинтэй

жолоочийн картыг, эсхүл хүчинтэй хяналтын картыг, эсхүл хүчинтэй аж ахуйн нэгжийн картыг оруулсан байна;

- үндсэн, эсхүл ээлжийн жолоочийн карт уншигч төхөөрөмжид хүчинтэй хяналтын картыг, эсхүл хүчинтэй аж ахуйн нэгжийн картыг оруулсан байна;

4) жолоочийн үйл ажиллагааны “жолоодлого” горимд жолоодлого үйлдэгдэж байх явцад аливаа уншигч төхөөрөмжид картыг хийсэн тухай мэдээллийг бүртгэнэ;

5) өмнөх өгөгдлүүдийг бичиж дуусгаагүй байхад төхөөрөмжөөс хүчээр гаргаж авсан жолоочийн картыг (засвар үйлчилгээний картыг) төхөөрөмжид хийх тохиолдолд өмнөх үйл явдлыг бүртгэж картын ашиглалтын сүүлчийн үйлдлийн төгсгөл буруу хийгдсэн тухай мэдээллийг карт дээр бичнэ;

6) замын хөдөлгөөний зөвшөөрөгдсөн хурдын хязгаарыг зөрчсөн тохиолдол бүрийн талаарх өгөгдлүүдийг бүртгэнэ;

7) “суурилуулалтын өгөгдлүүдийн тохиргоо” горимд тэжээл тасалдсан тохиолдлыг эс тооцон суурин төхөөрөмжийн тэжээл 100 милисекундээс илүү хугацаагаар тасарсан бусад тохиолдлуудын талаарх өгөгдлүүдийг бүртгэнэ;

8) хөдөлгөөний хурдын өгөгдлүүдийн урсгалд гарсан саатал, эсхүл хөдөлгөөний мэдрэгчээс ирэх болон хиймэл дагуулын системээс ирж буй өгөгдлүүдээр тодорхойлогдсон тээврийн хэрэгслийн бүртгэгдэж буй хурдын өгөгдлүүдийн зөрүүг бүртгэнэ;

9) тээврийн хэрэгслийг тээвэрлэх тохиолдолд ачаа горимоор бүртгэнэ;

10) хамгаалалтын системийг эвдэх оролдлогууд болон эвдсэн тохиолдлуудын талаарх мэдээллүүдийг бүртгэнэ:

- картыг ажиллуулах явцад гарсан гэмтэл, доголдлын талаарх мэдээлэл;
- суурин төхөөрөмжийн ажиллагаанд саатал (гацалт) гарах;
- дэлгэцийн гэмтэл;
- өгөгдлүүдийг ачаалах системийн саатал;
- хөдөлгөөн мэдрэгч дэх саатал;
- тахографын өгөгдлүүдийг боловсруулах төхөөрөмжийн саатал;
- тахографын өгөгдлүүдийг боловсруулах төхөөрөмжийн программ хангамжийн үйл ажиллагааны саатал;
- холбогч модулийн ажиллагааны саатал (суурин төхөөрөмжид холбогч модуль залгасан тохиолдолд);
- тээврийн хэрэгслийн огцом зогсолтын болон хэт хазайлтын мэдрэгчүүдийн ажиллагааны саатал;
- карт хийх төхөөрөмжийн ажиллагааны саатал; хэвлэх төхөөрөмжийн ажиллагааны саатал;

11) онцгой тохиолдлуудыг бүртгэнэ:

- тахографын тэжээл тасалдыг;
- ослын товчлуурыг дарах (суурин төхөөрөмжийн бүрэлдэхүүнд ийм функц болон холбогч модуль байгаа тохиолдолд);
- тээврийн хэрэгслийн огцом зогсолт (цохилт) ба аюултай хазайлтын (хөмрөлт) (суурин төхөөрөмжийн бүрэлдэхүүнд хурдатгалын мэдрэгч байгаа тохиолдолд);

12) ослын өмнөх 24 цагийн хугацааны тээврийн хэрэгслийн хөдөлгөөний координатуудын өгөгдлүүдийг оруулан хамгийн сүүлд бүртгэгдсэн 5 онцгой тохиолдлын талаарх мэдээллийг хуанлийн 60 хоногийн турш засваргүй хэлбэрээр,

4.10. Гүйцэтгэлийг шалгах явцад тахограф нь дараах үйлдлүүдийг хийнэ:

1) тэжээл өгөгдмөгц өөрийгөө шалгах дотоод системийн үзүүлэлтүүдийн тусламжтайгаар гэмтлийг дараах хэмжээсүүдийн дагуу илрүүлнэ:

- тахографын программ хангамжийн бүрэн бүтэн байдлыг хяналтын дүнгээр;
- санах ойн блоkd нэвтрэх боломж болон түүнд хадгалагдах өгөгдлүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгана;
- карт уншигч интерфeйсүүдэд нэвтрэх боломжуудыг шалгана;
- товчлууруудын гараар оруулах горимын ажиллагааг шалгана;
- хэвлэх төхөөрөмжийн ажиллагааг мэдээллийг хэвлэж гаргах замаар шалгана (тахографыг үйлдвэрлэгч байгууллагын заалтаар);
- дэлгэцийн ажиллагааг нүдээр шалгана;
- өгөгдлүүдийг хуулах явцад алдаа гарсан эсэхийг магадлан хуулсан өгөгдлийн үнэн зөв байдлыг шалгана;
- хөдөлгөөний мэдрэгчийн саадгүй ажиллагааг шалгана;
- шалгалтын дүнгүүдийг бүртгэж, дүнгийн өгөгдлүүдийг дэлгэц дээр гаргана.

4.11. Тахограф нь хяналтын карт, эсхүл аж ахуйн нэгжийн картыг оруулахад суурин төхөөрөмжийн, мөн жолоочийн картын санах ойд хадгалагдсан өгөгдлүүдийг гадны өгөгдөл зөөвөрлөгч рүү хуулах үйлдлийг гүйцэтгэнэ.

4.12. Тахограф нь гаднаас цахилгаан тэжээлгүй нөхцөлд ч, 365 хоногоос багагүй хугацаанд дараах өгөгдлүүдийг хадгална:

- жолоочийн картыг төхөөрөмжид хийсэн, гаргасан 2,190 үйлдэл;
- жолоочийн үйл ажиллагааны горим өөрчлөгдсөн 93,440 тохиолдол.

4.13. Тахограф нь жолоочийн картыг болон засвар үйлчилгээний картыг төхөөрөмжид хийсэн, гаргасан талаар дараах өгөгдлүүдийг хадгална:

- карт эзэмшигчийн овог, нэр
- картын дугаар. Хүчинтэй хугацаа дуусах огноо;
- картыг төхөөрөмжид хийсэн огноо, цаг;
- картыг төхөөрөмжид хийх үеийн тээврийн хэрэгслийн гүйлтийн тоолуурын заалт;
- картыг гаргасан огноо, цаг;
- картыг гаргах тээврийн хэрэгслийн гүйлтийн тоолуурын заалт;
- жолооч карт ашигласа өмнөх тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар;
- карт эзэмшигч өөрийн үйл ажиллагааны талаарх гараар оруулсан мэдээлэл;

4.14. Тахограф нь жолоочийн үйл ажиллагааны талаарх дараах өгөгдлүүдийг хадгална:

- үндсэн болон ээлжийн жолоочийн үйл ажиллагааны горимын өөрчлөлтийн;
- жолоочийн картыг оруулах ба гаргах үйлдэл;
- жолоодлогын хэлбэр: “багаар”, “ганцаараа”;
- уншигч төхөөрөмжийн байдал: “үндсэн жолоочийн”, “ээлжийн жолоочийн”;
- зохих уншигч төхөөрөмж картын байрлал: “картыг хийсэн”, “картыг хийгээгүй”;
- үйл ажиллагааны горимын төрлүүд: “жолоодлого”, “бэлэн байдал”, “ажил”, “завсарлага/амралт”;

- үндсэн жолооч (ээлжийн жолоочийн) үйл ажиллагааны горимын өөрчлөлтийн огноо ба цаг.

4.15. Тахограф нь тээврийн хэрэгслийн маршрут, байршлын координатуудын тааларх дараах өгөгдлүүдийг хадгална:

- тээврийн хэрэгслийн маршрутын огноо, цаг ба координатуудын;
- тээврийн хэрэгслийн өдөр тутмын жолоодлогын хугацаа элхэх болон дуусах байршлын огноо, цаг ба координатууд;
- тээврийн хэрэгслийн огноо, цаг ба туулсан зам, (жолоочийн оруулснаар) өдөр тутмын жолоодлогын хугацаа эхэлсэн болон дууссан байршлын газрын нэр, заасан өгөгдлүүдийг гараар оруулсан үндсэн жолоочийн (ээлжийн жолоочийн) картын дугаар.

4.16. Тахограф нь өдөр бүр (00 ц, 00 мин-д) тээврийн хэрэгслийн өнгөрөгч хоногт туулсан замын өгөгдлүүдийг бүртгэн тэдгээрийг 365 хоногоос багагүй хугацаанд хадгална.

4.17. Тахограф нь тээврийн хэрэгслийг хөдөлгөөнтэй байсан сүүчийн 24 цагийн туршид секундэд нэг удаа бүртгэгдсэн хурдны мэдрэгчийн мэдээллүүдийг хадгална.

4.18. Тахограф нь дараах мэдээллүүдийг хадгална:

- сүүлийн арван хоног бүрт зохих картгүйгээр жолоо барьсан хамгийн урт хугацааны эхлэлийн огноо ба цаг, төгсгөлийн огноо ба цаг, тухайн өдөр бүртгэгдсэн ижил төстэй үйл явдлын тоо;
- сүүлчийн 365 хоногийн таван удаагийн зохих картгүйгээр жолоо барьсан хамгийн урт хугацааны эхлэлийн огноо ба цаг, төгсгөлийн огноо ба цаг, тухайн өдөр бүртгэгдсэн ижил төстэй үйл явдлын тоо;
- сүүлчийн арав хоногийн хугацаанд жолоодлого эхэлсний дараа төхөөрөмжид картыг хийсэн огноо ба цаг, картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код, тухайн өдөр бүртгэгдсэн ижил төстэй үйл явдлын тоо;
- картын ашиглалтын төгсгөлийг буруу дуусгасан сүүлчийн арван тохиолдолд картыг төхөөрөмжид хийсэн огноо ба цаг, картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код, картыг хамгийн сүүлд ашигласан огноо, картыг төхөөрөмжид хийсэн огноо ба цагийн талаарх картад бичигдсэн мэдээлэл, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар;
- хуанлийн сүүлчийн арав хоногт бүртгэгдсэн хамгийн өндөр дундаж хурдны болон үйл явдлын эхлэлийн огноо ба цаг, үйл явдлын төгсгөлийн огноо ба цаг, үйл явдлын үед хэмжигдсэн дээд хурд, үйл явдлын үед хэмжигдсэн хурдны дундаж заалт, картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код, тухайн өдөр бүртгэгдсэн ижил төстэй үйл явдлын тоо;
- сүүлчийн 365 хоногийн хугацаанд хамгийн их хурд хэтрүүлсэн таван тохиолдол болон үйл явдлын эхлэлийн огноо ба цаг, үйл явдлын төгсгөлийн огноо ба цаг, үйл явдлын үед хэмжигдсэн дээд хурд, үйл явдлын үед хэмжигдсэн хурдны дундаж заалт, картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код, тухайн өдөр бүртгэгдсэн ижил төстэй үйл явдлын тоо;
- тахографын сүүлийн тохируулгаас хойш бүртгэгдсэн анхны хурд хэтрүүлэлт болон үйл явдлын эхлэлийн огноо ба цаг, үйл явдлын төгсгөлийн огноо ба цаг, үйл явдлын үед хэмжигдсэн дээд хурд, үйл явдлын үед хэмжигдсэн хурдны дундаж заалт, картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код, тухайн өдөр бүртгэгдсэн ижил төстэй үйл явдлын тоо;

- сүүлийн арав хоног тутмын цахилгаан тэжээл сэргээгдсэнээс хойш минутын нарийвчлалтай бүртгэгдсэн хамгийн урт үргэлжилсэн цахилгаан тэжээл тасралт болон үйл явдлын эхлэлийн огноо ба цаг, үйл явдлын төгсгөлийн огноо ба цаг, картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код, тухайн өдөр бүртгэгдсэн ижил төстэй үйл явдлын тоо;
- сүүлийн 365 хоногт цахилгаан тэжээл сэргээгдсэнээс хойш минутын нарийвчлалтай бүртгэгдсэн хамгийн урт цахилгаан тэжээл тасалдсан таван тохиолдол болон үйл явдлын эхлэлийн огноо ба цаг, үйл явдлын төгсгөлийн огноо ба цаг, тахографт оруулсан байгаа картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код, тухайн өдөр бүртгэгдсэн ижил төстэй үйл явдлын тоо;
- сүүлийн арав хоног тутмын хөдөлгөөний өгөгдлүүдийн алдааны хамгийн урт үргэлжилсэн хугацаа, үйл явдал болон үйл явдлын эхлэлийн огноо ба цаг, үйл явдлын төгсгөлийн огноо ба цаг, тахографт оруулсан байгаа картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код тухайн өдөр бүртгэгдсэн ижил төстэй үйл явдлын тоо;
- сүүлийн 365 хоногийн хөдөлгөөний өгөгдлүүдийн хамгийн урт таван алдаа үргэлжилсэн үйл явдал болон үйл явдлын эхлэлийн огноо ба цаг, үйл явдлын төгсгөлийн огноо ба цаг, тахографт оруулсан байгаа картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код, тухайн өдөр бүртгэгдсэн ижил төстэй үйл явдлын тоо;
- хамгаалалтын системийг эвдэх зэрэг аюулгүй байдлын зөрчлийн сүүчийн арван оролдлогыг болон үйл явдлын эхлэлийн огноо ба цаг, үйл явдлын төгсгөлийн огноо ба цаг, картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код.

4.19. Тахограф нь тахографын төхөөрөмж болон жолоочийн картын ажиллагаанд илэрсэн дараах саатлуудын талаарх өгөгдлүүдийг бүртгэж, хадгална:

- тахографын ажиллагааны саатал төрөл тус бүрээр сүүлийн арван саатал, саатлын эхлэлийн бөгөөд төгсгөлийн огноо ба цаг, саатлын төрөл, картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код;
- суурилуулалтын өгөгдлүүдийн сүүлийн тохиргооноос хойшхи тахографын ажиллагааны саатлын эхлэл болон төгсгөлийн огноо ба цаг, алдааны төрөл, картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код;
- жолоочийн картын ажиллагааны сүүлчийн арван саатал болон саатлын эхлэл төгсгөлийн огноо ба цаг, алдааны төрөл, картын төрөл, картын дугаар болон үйлдвэрлэгч байгууллагын код;

4.20. Тахограф нь суурилуулалтын өгөгдлүүдийн сүүлчийн таван тохиргооны талаарх өгөгдлүүдийг бүртгэж, хадгална:

- өгөгдлүүдийн тохиргооны зорилго (анхны тохиргоо, идэвхжүүлэлт, засварын (үйлчилгээний) дараа, тохируулга);
- анхдагч өгөгдлүүдийн тохиргоог хийсэн засвар үйлчилгээний газрын нэр болон албан ёсны хаяг;
- засвар үйлчилгээний картын дугаар ба үйлчлэх хугацаа;
- тээврийн хэрэгслийн таниулах өгөгдлүүд (өмнөх болон шинэ);
- хурд хязгаарлах төхөөрөмжийн тохируулга хийх;
- гүйлтийн тоолуурын тохируулга хийх (өмнөх болон шинэ);
- огноо ба цагийг тохируулах (өмнөх болон шинэ).

4.21. Тахограф нь дараах огноо ба цагийг тохируулгын талаарх өгөгдлүүдийг бүртгэж, хадгална (цагийн автомат тохируулгын өгөгдлүүд тахографын санах ойд бүртгэгдэхгүй):

- өмнөх болон шинэ заалтуудыг оруулсан огноо ба цагийн сүүлчийн тохиргоо;
- төлөвлөгөөт техник үйлчилгээнд хамаарахгүй сүүлчийн техник үйлчилгээнээс хойш, өмнөх болон шинэ заалтуудыг оруулсан, огноо ба цагийн таван тохиргоо;

4.22. Тахограф нь дараах 20 хяналтын ажиллагааны талаарх өгөгдлүүдийг бүртгэж, хадгална:

- хяналтын огноо ба цаг;
- хяналтын картын дугаар;
- өгөгдлүүдийн гаргалт (дэлгэц дээр, хэвлэх, суурин төхөөрөмжөөс буулгасан, жолоочийн картаас буулгасан).

4.23. Тахограф нь тээврийн хэрэгслийн эзэмшигчийн тавьсан сүүлчийн 20 блокын талаарх өгөгдлүүдийг бүртгэж, хадгална:

- блок тавьсан огноо ба цаг;
- блок гаргасан огноо ба цаг;
- аж ахуйн нэгжийн картын дугаар;
- тээврийн хэрэгсэл эзэмшигч;
- тээврийн хэрэгсэл эзэмшигчийн албан ёсны хаяг эсхүл байнгын оршин суух (байршлын) хаяг.

4.24. Тахограф нь “аж ахуйн нэгж”, эсхүл “суурилуулалтын өгөгдлийг тохируулах” горимд гадаад зөөвөрлөгч рүү хамгийн сүүлд байршуулсан дараах мэдээллүүдийг бүртгэж хадгална:

- мэдээллийг байршуулсан огноо, цаг;
- аж ахуйн нэгжийн эсхүл засвар үйлчилгээний картын дугаар;
- тээврийн хэрэгсэл эзэмшигчийн овог, нэр эсхүл засвар үйлчилгээний газрын нэр.

4.25. Тахограф нь “үл хамаарах” болон “усан гаталгаа/галт тэргээр тээвэрлэгдэх” байдлуудын талаарх өгөгдлүүдийг бүртгэж, хадгална:

- байдлын талаарх мэдээллийг оруулсан огноо ба цаг;
- нөхцөл байдлын төрөл болон үйлчлэх цаг.

4.26. Тахограф нь жолоочийн картад хадгалагдаж буй дараах мэдээллийг ачаална:

1) картын таниулах өгөгдлүүд, жолоочийн таниулах өгөгдлүүд, түүний өмнө ашиглаж байсан тээврийн хэрэгслүүд;

2) картыг гаргасан сүүлчийн үйлдлийн огноо, цаг болон картыг гаргах үед жолоочийн сонгосон үйл ажиллагааны горим;

3) картын ашиглалтын сүүлийн үйлдлийн төгсгөл зөв хийгдсэнг шалгасан талаарх өгөгдлүүд;

4) өмнөх болон одоогийн долоо хоногт тээврийн хэрэгслийг тасралтгүй жолоодсон хугацаа, завсарлагуудын нийлбэр цаг болон жолоодлогын нийлбэр цагийн талаарх өгөгдлүүд;

5) жолоочийн картад бичигдсэн мэдээллийг хэвлэж гаргасан талаарх өгөгдлүүд;

б) жолоочийн картаас гадны зөөвөрлөгч рүү мэдээлэл байршуулсан талаарх өгөгдлүүд.

4.27. Тахограф нь “өгөгдлүүдийг ачаалах” гурван оролдлогын дараа мэдээлэл ачаалагдаагүй тохиолдолд карт гэмтэлтэй эсхүл хүчингүй гэсэн мэдээллийг дэлгэц дээр гаргаж, бүртгэнэ.

4.28. Тахограф нь дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

1) Жолоочийн, эсхүл засвар үйлчилгээний картад (картыг төхөөрөмжид хиймэгц) картыг ашигласан огноо, цаг, тээврийн хэрэгслийн гүйлтийн тоолуурын заалтын өгөгдлүүд зэргийг багтаасан картын ашиглалтын үеийн өгөгдлүүдийг буулгана;

2) Жолоочийн, эсхүл засвар үйлчилгээний картад (картыг төхөөрөмжид хиймэгц) тухайн картыг тахографт хийсэн хугацаатай холбоотой бүртгэгдсэн өгөгдлүүдийг буулгана.

4.29. Тахограф нь өгөгдлүүдийг дэлгэц дээр гаргахдаа дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

1) дэлгэцээр латин болон кирилл тэмдэгтийн сонголтыг дэмжинэ;

2) минимум өндөр 5 мм ба өргөн 3,5 мм хэмжээтэй 20-иос цөөнгүй тэмдэгтээс бүрдэх мэдээллүүдийг дэлгэц дээр гаргана;

3) тээврийн хэрэгслийн туулсан замыг заахдаа тооны араас “км” тэмдэглэгээг, хурдын заалт дээр “км/ц”-г дүрсэлнэ;

4) дэлгэц дээр **пиктограммуудыг** гаргана;

5) үндсэн тохиргооны дагуу дараах өгөгдлүүдийг дэлгэц дээр гаргана:

- огноо болон орон нутгийн цаг;
- тээврийн хэрэгслийн гүйлтийн талаарх өгөгдлүүд;
- тээврийн хэрэгслийн хурд;
- ажлын горим;
- жолоочийн үйл ажиллагааны төрөл;
- “жолоодлого” горимд – тасралтгүй жолоо барьсан хугацаа болон нийт амрах завсарлагуудын үргэлжлэх хугацаа;
- өөр горимд – жолоочийн сонгосон үйл ажиллагааны горимын үргэлжлэх хугацаа болон тухайн цагийн байдлаар нийт завсарлагуудын үргэлжлэх хугацаа;
- “экипаж” горимд – ээлжийн жолоочийн үйл ажиллагааны горим ба үйл ажиллагааных нь үргэлжлэх хугацаа (тухайн функцыг сонгосноос хойш);
- ажлын горимын өөрчлөлтүүдийн мэдээлэл;
- картыг төхөөрөмжид хийх үед тухайн карт эзэмшигчийн овог;
- “үл хамаарах” нөхцөлийн талаарх мэдээлэл;

6) дэлгэц дээр дараах анхааруулах мэдээллийг гаргана:

- “хүчингүй карт хийсэн”;
- “хурд хэтрүүлэлт”;
- “цахилгаан тэжээл тасарсан”;
- 4.8-ын 1-д заасан үйл явдлуудын талаар;

7) цэсийг ашиглан өгөгдөх дараах командуудын гүйцэтгэлийн мэдээллийг дэлгэц дээр гаргана:

- “автомашинь талаарх өгөгдлүүд”;

- “үндсэн жолоочийн өгөгдлүүд”;
- “ээлжийн жолоочийн өгөгдлүүд”;
- “хурдны талаарх өгөгдлүүд”;
- “үйл явдлууд болон гэмтлүүдийн талаарх өгөгдлүүд”;
- “өгөгдлүүдийг ачаалах”;

8) зохих командын дагуу дэлгэц дээр дараах өгөгдлүүдийг гаргана:

- огноо, UTC (SU) үндэсний координатжуулсан цагийн хэмжээс болон жолооч гараар оруулсан орон нутгийн цаг;
- үндсэн жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодсон цаг ба амарсан цаг;
- үндсэн жолоочийн өмнөх болон тухайн долоо хоногт тээврийн хэрэгсэл жолоодсон нийт цаг;
- ээлжийн жолоочийн өмнөх болон тухайн долоо хоногт тээврийн хэрэгсэл жолоодсон нийт цаг;
- үндсэн жолоочийн тухайн улиралд тээврийн хэрэгсэл жолоодсон нийт цаг;
- хоёрдугаар жолоочийн тухайн улиралд тээврийн хэрэгсэл жолоодсон нийт цаг;

4.30. Тахограф нь өгөгдлүүдийг хэвлэхдээ дараах ажиллагааг хангана:

- 1) хэвлэж гаргахаас өмнө – жолоочийн картын санах ойд өгөгдлүүдийг бичих;
- 2) жолоочийн картыг гаргаагүй үед “карт дээр бичигдсэн жолоочийн үйл ажиллагааны талаарх өгөгдлүүдийг” өдөр тутам хэвлэн гаргаж өгөх;
- 3) засвар үйлчилгээний картыг эсхүл жолоочийн картыг төхөөрөмжид зэрэг хийсэн үед “үйл явдал болон гэмтлийн талаарх өгөгдлүүдийн хэвлэлийг” гаргаж өгөх;
- 4) жолоочийн болоод хяналтын картуудыг төхөөрөмжид зэрэг хийсэн үед зохих командын дагуу сонголтыг хэвлэж гаргах;
- 5) цаас цэнэглэсний дараа хэвлэлтийг эхнээс нь дахин эхлүүлэх
- 6) санах ой болон картуудын санах ойд байгаа мэдээллийг дараах зургаан төрлөөр хэвлэж гаргах:

- “жолоочийн картад бичигдсэн жолоочийн үйл ажиллагааны горимын талаарх өгөгдлүүдийн өдөр тутмын хэвлэлт”;
- “тахографт бичигдсэн жолоочийн үйл ажиллагааны талаарх өгөгдлүүдийн өдөр тутмын хэвлэлт”;
- “жолоочийн карт дээр хадгалагдах үйл явдал ба алдаануудын талаарх өгөгдлүүдийн хэвлэлт”;
- “тахографт бичигдсэн үйл явдал ба гэмтлүүдийн талаарх өгөгдлүүдийн хэвлэлт”;
- “тээврийн хэрэгслийн техник үзүүлэлтүүдийн хэвлэлт”
- “хурд хэтрүүлэлтийн талаарх өгөгдлүүдийн хэвлэлт”.

4.31. Хэвлэсэн өгөгдлүүд нь холбогдох мэдээллүүд дараах өгөгдлүүдийг агуулсан QR кодтой байна:

- 1) одоогийн цаг, огноо;
- 2) тээврийн хэрэгслийн байршлын координатууд;
- 3) тахографын серийн дугаар.

4.32. Тахографын хэвлэх төхөөрөмж дараах үүрэгтэй:

- 1) минимум хэмжээ нь 2.1 мм өндөртэй ба 1.5 өргөнтэй, нэг мөрд 24 тэмдэгт хэвлэх боломжтой байх;

2) латин болон кирилл тэмдэгтийн сонголтыг дэмждэг байх.

4.33. Тахограф нь дараах ажиллагааг хангана:

1) ямар ч үйл явдал эсхүл гэмтлийг илрүүлсэн тохиолдолд дэлгэц дээр дүрст анхааруулгыг дуут дохионы хамтаар 30 секундээс багагүй хугацааг гаргах;

2) тухайн мэдээллийг хүлээж авснаа баталгаажуулж тахографын товчлуур дээр дарахад дуут дохиог таслах;

3) тээврийн хэрэгслийг тасралтгүй жолоодох зөвшөөрөгдсөн хугацааны дээд хязгаар хүрэхээс өмнө 15 минутын өмнө болон хүрэх даруй жолоочид анхаарулга өгөх;

4) анхааруулгын шалтгааныг дэлгэц дээр гаргаж, хэрэглэгч тухайн мэдээллийг хүлээж авснаа баталгаажуулан тахографын товчлуур дээр дартал харагдахаар хадгалах;

4.34. Тахограф нь “суурилуулалтын өгөгдлүүдийн тохиргоо” горимд дараах боломжтой байна:

1) огноо ба цагийн тохиргоог хийх;

2) тээврийн хэрэгслийн туулсан замын тоолуурын заалтад тохиргоо хийх;

3) тогтоосон хурдны хязгаарыг тохируулах;

4.35. Тахограф нь дараах горимд шилжих боломжтой байна:

1) “ажлын”:

- уншигч төхөөрөмжүүдэд тахографын “үндсэн жолооч” болон “ээлжийн жолооч”-ийн картууд байхгүй тохиолдолд;

- “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид үндсэн жолоочийн карт байгаа бөгөөд “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид карт байхгүй тохиолдолд;

- үндсэн жолоочийн карт “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид байгаа бөгөөд “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид карт байхгүй тохиолдолд;

- “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид үндсэн жолоочийн карт байгаа бөгөөд “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид өөр жолоочийн карт байгаа тохиолдолд;

- “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид засвар үйлчилгээний карт байгаа бөгөөд “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид хяналтын карт эсхүл аж ахуйн нэгжийн карт байгаа тохиолдолд;

- “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид засвар үйлчилгээний карт байгаа бөгөөд “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид хяналтын эсхүл аж ахуйн нэгжийн карт байгаа тохиолдолд;

- “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид хяналтын карт байгаа бөгөөд “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид аж ахуйн нэгжийн карт эсхүл засвар үйлчилгээний карт байгаа тохиолдолд;

- “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид хяналтын карт байгаа бөгөөд “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид аж ахуйн нэгжийн карт эсхүл засвар үйлчилгээний карт байгаа тохиолдолд;

2) “хяналт”:

- “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид хяналтын карт байгаа бөгөөд “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид карт байхгүй тохиолдолд;

- “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид хяналтын карт байгаа бөгөөд “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид жолоочийн карт байгаа тохиолдолд;

- “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид хяналтын карт байгаа бөгөөд “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид карт байхгүй тохиолдолд;
- “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид хяналтын карт байгаа бөгөөд “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид жолоочийн карт байгаа тохиолдолд;

3) “өгөгдлийн тохиргоо хийх”:

- “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид засвар үйлчилгээний карт байгаа бөгөөд “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид карт байхгүй тохиолдолд;
- “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид засвар үйлчилгээний карт байгаа бөгөөд “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид карт байхгүй тохиолдолд;
- “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид засвар үйлчилгээний карт байгаа бөгөөд “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид үндсэн жолоочийн карт эсхүл өөр засвар үйлчилгээний карт байгаа тохиолдолд;
- “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид засвар үйлчилгээний карт байгаа бөгөөд “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид үндсэн жолоочийн карт эсхүл өөр засвар үйлчилгээний карт байгаа тохиолдолд;

4) “аж ахуйн нэгж”:

- “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид аж ахуйн нэгжийн карт байгаа бөгөөд “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид карт байхгүй тохиолдолд;
- “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид аж ахуйн нэгжийн карт байгаа бөгөөд “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид карт байхгүй тохиолдолд;
- “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид аж ахуйн нэгжийн карт байгаа бөгөөд “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид үндсэн жолоочийн карт байгаа тохиолдолд;
- “ээлжийн жолооч” уншигч төхөөрөмжид аж ахуйн нэгжийн карт байгаа бөгөөд “үндсэн жолооч” уншигч төхөөрөмжид үндсэн жолоочийн карт байгаа тохиолдолд;

Тав. Тахографыг ашиглах

5.1. тахографыг дараах байдлаар ашиглана.

5.1.1. Жолооч нар – тээврийн хэрэгсэл жолоодох хугацаа болон амралт, хөдөлмөр, амралтын горимын мэдээллийг бүртгэх зорилгоор;

5.1.2. Тээврийн хэрэгслийн эзэмшид – тахографын хэвийн үйл ажиллагааг хянах болон жолооч нарын тээврийн хэрэгслийн жолоодох хөдөлмөр, амралтын горимыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор;

5.1.3. Хяналтын байгууллагууд - тахографын хэвийн үйл ажиллагаа болон жолооч нар тээврийн хэрэгслийн жолоодох хөдөлмөр, амралтын горимыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих зорилгоор;

5.1.4. Засвар үйлчилгээний төвүүд – тахограф суурилуулах, шалгаж турших, техникийн үйлчилгээ болон засвар хийх зорилгоор;

5.2. Тээврийн хэрэгсэлд зөвхөн энэхүү журам болон холбогдох стандартын шаардлага хангасан “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын бүртгэсэн загварын бүртгэлд орсон нэг хяналтынн төхөөрөмжийг суурилуулан, идэвхжүүлж ашиглана.

5.3. Тахографт мэдээллийг ямар нэгэн засваргүйгээр хадгалах санах ойн төхөөрөмж ашиглана.

5.4. Жолооч нь зөвхөн тухайн жолоочид олгосон жолоочийн хүчинтэй нэг картыг ашиглах үүрэгтэй. Хэрэв жолоочид олгосон хоёр картын хоёр дахь картын хүчинтэй хугацаа нь нэг дэх картын хүчинтэй хугацаа дууссанаас хойш эхлэх нөхцөлд хоёр карт ашиглахыг зөвшөөрнө.

5.5. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь тахографын хэрэглээг хангах зорилгоор дараах арга хэмжээг авна:

5.5.1. Дараах мэдээллийн жагсаалтад бүртгэл хөтлөх:

- Тахографууд болон картуудын загваруудын талаар;
- Тахографын, картын үйлдвэрлэгч байгууллага болон засварын төвүүдийн олгосон, идэвхжүүлсэн, устгасан тахограф, карт бүрийн бүртгэл;
- Тахографын суурилуулалт, шалгалт, техникийн үйлчилгээ болон засварын үйл ажиллагаа эрхэлдэг газруудын бүртгэл;
- Тахографын ашиглалтыг хариуцсан этгээдүүдий бүртгэл;
- Тахографын үйлчилгээн хийх засварын ажилтнуудын бүртгэл;
- Тахографын ашиглалт болон засварын үйлчилгээ хариуцах эрх бүхий этгээдэд олгогдсон итгэмжлэлийн талаарх бүртгэл;

5.5.2. Доор заасан үйл ажиллагааг зохион байгуулалтаар хангах:

- Карт шинээр олгох, солих, шинэчлэх хүсэлтүүдийг хүлээн авах, бүртгэлжүүлэх;
- Тахографын ашиглалт болон засвар үйлчилгээг хариуцах эрх бүхий этгээдэд олгогдсон итгэмжлэлийг бүртгэх өргөдлийг хүлээн авах, бүртгэлжүүлэх;
- Тахографын ашиглалт, засвар үйлчилгээ хариуцах эрх бүхий этгээдэд олгогдсон итгэмжлэл болон тахографын картанд дугаар олгох;

5.5.3. картын үйлдвэрлэл, идэвхижүүлэлт, олголт, дамжуулалтын талаарх мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулах;

5.5.4. Холбогдох жагсаалтаас мэдээлэл өгөх

5.5.5. Тахограф, тахографын картын загварууд болон засварын төвүүдийн талаарх мэдээллийг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын албан ёсны цахим хуудсанд (“хүчинтэй”/”архивын”) гэсний аль нэг тохирох тэмдэглийг хийж байршуулах ба тэдгээрт орсон өөрчлөлтийн огноог мөн байршуулна.

5.5.6. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь тахографын хэрэглээг хангах зорилгоор тахограф, тахографын карт, засвар үйлчилгээний төвүүд, засварын ажилтнууд, тахографыг ашиглах болон засварын ажилтнуудын итгэмжлэлийн талаарх мэдээллийг үйлдвэрлэгч, тээврийн хэрэгслийн эзэмшигч, тахографыг ашиглах эрх бүхий этгээд, засварын ажилтан болон засварын төвүүдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг үндэслэн дараах жагсаалтын дагуу ангилан бүртгэнэ. Үүнд:

- 1) Тахографын загваруудыг;
- 2) Тахографын картын загваруудыг;
- 3) Засварын төвүүдийг;

- 4) Тахограф, тахографын картын тоо ширхэгийг;
- 5) Тахографын ашиглалт хариуцах этгээдүүдийг;
- 6) Тахографын засварын ажилтнуудыг;
- 7) Тахографын ашиглалт хариуцах этгээдүүдэд олгосон итгэмжлэлийг;
- 8) Тахографын засварын ажилтнуудад олгосон итгэмжлэлийг.

5.5.7. “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ нь тахографын ашиглалтын нөхцөлийг хангах зорилгоор тахограф, тахографын карт, засвар үйлчилгээний төвүүд, засварын ажилтнууд, тахографыг ашиглах болон засварын ажилтнуудын итгэмжлэлийн талаарх мэдээллийн талаарх бүртгэлийг доорх мэдээллийн үндсэн дээр хийнэ. Үүнд:

1) Үйлдвэрлэгч-байгууллага болон засварын төвүүдийн албан ёсны нэр, хаягийн мэдээлэл;

2) Тахографыг ашиглах этгээд болон засварын үйл ажиллагаа эрхлэх хувь хүн болон хуулийн этгээдийн удирдлагын овог нэрний талаарх мэдээлэл;

3) Тахограф, карт, засварын төвүүдийн мэдээллийг холбогдох жагсаалтад орсон мэдээллийн дагуу бүртгэнэ. Үүнд:

Тахограф болон тахографын картын техникийн үзүүлэлтүүд;

Тахограф болон тахографын карт нь холбогдох туршилтаар чанар, стандартын шаардлагыг хангасан тухай дүгнэлт, гэрчилгээ.

5.5.8. Тахографыг ашиглах этгээд болон засварын ажилтнуудад олгосон итгэмжлэлийн талаарх мэдээллийг «..... тухай» хуулийн/журмын дагуу

5.5.9. Дээрх мэдээллийг баталгаажуулах бичиг баримтууд(тэдгээрийн хуулбар).

5.5.10. Үйлдвэрлэгчийн олгосон, идэвхжүүлсэн, угсасан тахограф, картын талаарх мэдээллийг эзэмшигчийн гаргасан холбогдох өргөдөл, хүсэлтийн дагуу эзэмшигчид өгнө.

5.6. Тээврийн хэрэгслийн жолоочийн үүрэг:

1) Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн эхлүүлэхээс өмнө (ажлын өдөр эхлэхэд эсхүл өөрийн ээлжийн өмнө) өөрийн эзэмшлийн картыг тахографын зүүн талын үүрэнд шургуулан картын пин-кодоо оруулах (багаар буюу 2 жолооч ажиллаж байгаа тохиолдолд 2 дахь жолооч мөн адил өөрийн эзэмшлийн картыг тахографын баруун үүрэнд шургуулан 1-р жолоочийн карт бүрэн танигдсаны дараа пин-кодоо оруулна);

2) Тахографын зааварчилгааны дагуу тээврийн хэрэгслийг жолоодож эхэлсэн байршил болон хөдөлгөөний мэдээллийг гараар оруулах функцийг идэвхижүүлэх эсхүл алгасах үйлдлийг хийх. Энэ үйлдлийг алгассан тохиолдолд тохиргоо автоматаар хийгдэж ингэснээр 1 ба 2-р жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодож эхэлсэн байршил болон жолоодсон хугацаа автоматаар бүртгэгдэж эхэлнэ;

3) Тээврийн хэрэгслийн жолоодлого дуусмагц тахографын зааварчилгааны дагуу жолоодлого дууссан байршил болон цагийн мэдээллийг оруулан өөрийн картаа тахографтаас гарган/салган авах;

4) Шаардлагатай тохиолдолд хяналтын байгууллага болон байцаагчид тахограф болон тахографын картын мэдээллийг шалгах боломж олгохоос гадна тахограф дээр бүртгэгдсэн/хадгалагдсан мэдээллийг хэвлэхэд бэлтгэж өгөх;

5) Мэдээллийг хэвлэх;

6) Жолоочийн гэмтэлтэй картыг ашиглахгүй байх;

7) Хөдөлгөөний явцад/үед картыг сугалж авахгүй байх;

8) Жолоочийн хугацаа дууссан карт ашиглахгүй байх;

9) Энэхүү журмын дагуу тахографын ашиглалтыг хангах.

5.9. Жолоочид дараах зүйлийг **хориглоно**. Үүнд:

1) Ажиллагаагүй (түгжигдсэн, өөрчлөгдсөн, эвдэрсэн ... г.м.) болсон эсхүл шаардлага хангаагүй тахографыг ашиглах;

2) Тахографыг жолоочийн картгүйгээр ашиглах;

3) Ашиглалтын хугацаа нь дууссан тахограф ашиглах;

4) Тахографын загварын жагсаалтын бүртгэлд ороогүй тахограф ашиглах;

5) Тахографт бүртгэгдсэн мэдээллийг түгжих/блоклох/, мэдээллийг засварлах, эсхүл хуурамч буруу мэдээлэх оруулах;

6) Тахографт болон жолоочийн картанд хадгалагдсан болон бичигдсэн мэдээллийг устгах;

7) Шалгалтын явцад шаардлагад нийцсэн тухай үзүүлэлтийн мэдээлэл нь Стандарт хэмжил зүйн мэдээллийн санд бүртгэгдээгүй, эсхүл тухайн тахографт хэмжилтийн хэрэгслийн зааварт нийцэх хэмжилтийн хэрэгслийн батаглгааны тэмдэг болон баталгаажуулалтын тэмдэг байхгүй, мөн тахографын баталгаажуулалтын гэрчилгээнд баталгаажуулалт хийсэн хүний гарын үсэг, хүчин төгөлдөр тэмдгээр баталгаажсан тухай бичилт тахографын паспортод хийгдээгүй тахографыг ашиглах.

5.7. Тээврийн хэрэгслийн эзэмшигчийн үүрэг.

1) “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын бүртгэлийн жагсаалтанд орсон засварын төвүүдээр дамжуулан тээврийн хэрэгсэлд тахограф суурьлуулах, суурьлуулсан тахографын хяналт шалгалт, техникийн засвар, үйлчилгээг хийлгэх;

2) Тахографыг үйлдвэрлэгчээс гаргасан гарын авлага, зааврын дагуу ашиглах;

3) Жолоочийг хэвлэх цаас гэх мэт хэрэглээний зохих материалуудаар хангах;

4) Жолоочийн картнаас мэдээллийг 28 хоног тутамд татаж авах;

5) Жолоочийн картнаас татаж авсан мэдээллийг тээврийн хэрэгслийн эзэмшигч өөрийн мэдээллийн санд 1 жилийн хугацаанд хадгалах ба шаардлагатай тохиолдолд хяналтын байгууллагад холбогдох өгөгдлийг мэдээллийн сангаас гаргаж өгөх, мэдээллийн санд нэвтрэх боломжоор хангах;

6) Тахографыг ашиглалтаас гаргаж актлахдаа санах ойн төхөөрөмжийг салган авч мөн 1 жилийн хугацаанд хадгална;

7) Гэмтэлтэй эсхүл үйл ажиллагаа нь доголдсон тахографыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын бүртгэлийн жагсаалтад орсон засварын төвүүдэд хүргүүлэх;

8) Ашиглалтаас хассан тахографын мэдээллийг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т хүргүүлэх;

9) Тахографыг акталж, хэрэглээнээс гаргахаас өмнө түүнд хадгалагдсан мэдээллийг тээврийн хэрэгсэл эзэмшигчийн мэдээлийн санд хуулж архивлан авч, нэг жилийн хугацаанд хадгалах;

10) Тахографын ашиглалтын заавар/гарын авлагыг тээврийн хэрэгсэлд байршуулах;

11) «.....» тухай хуульд зааснаар тахографын баталгаажуулалтыг тогтмол зохион байгуулах.

Зургаа. Тээврийн хэрэгсэлд суурьлуулсан тахографыг засварлах, техникийн үйлчилгээ үзүүлэх

6.1.Энэхүү журам нь засварын төвүүдийн доор заасан үйл ажиллагааг зохицуулна:

1) Тахографыг ашиглалтад оруулах;

2) Тахографын техникийн үйлчилгээ;

3) Тавигдсан шаардлагад нийцүүлэх зорилгоор тахографыг засварлах, түүний загвар бүтэц болон тахографын программын өгөгдөлд өөрчлөлт оруулах (цаашид тахографын программын шинэчилэл гэх).

4) Тахографыг солих;

5) Тахографыг ашиглалтаас хасах.

6.2.Тахографыг ашиглалтад оруулах гэдэгт доорх ажлуудыг ойлгоно:

1) Үйлдвэрлэгчийн гаргасан техникийн бичиг баримтад заасан шаардлагын дагуу тахографыг ашиглалтад оруулах;

2) Тахографт мэдээллүүдийг оруулах, тахографыг тохируулах, алдаагүй ажиллагаа болон тахографын үзүүлэлтийн нарийвчлалыг үйлдвэрлэгчээс гаргасан техникийн баримт бичгийн дагуу шалгах;

3) Тахографын мэдээллийг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т илгээх;

6.3.Тахографын техникийн засвар үйлчилгээ гэдэгт:

1) Тахографын алдаагүй зөв ажиллагаа болон үзүүлэлтийн нарийвчлалыг шалгахыг;

2) Тахографыг тохируулах.

6.4.Тахографын алдаагүй зөв ажиллагаа, үзүүлэлтийн нарийвчлал, түүнчлэн тахографын тохируулгыг доор заасан нөхцөл хангагдсан тохиолдолд хийнэ. Үүнд:

1) Тээврийн хэрэгсэл нь жолоочтой ажиллах горимд байх;

2) Тээврийн хэрэгслийн дугуйны даралт нь тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгч байгууллагаас гаргасан зааврын дагуу байх;

3) Дугуйн элэгдэл нь “Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг, оношлогоо хийх журам”-д заасан техникийн шаардлагад нийцсэн байх;

4) Тээврийн хэрэгсэл нь өөрийн хөдөлгүүрээр хөдөлгөөнийг эхлүүлж, ижил бүтэцтэй хатуу хучилттай тэгш зам талбайд, эсхүл түүний орлох туршилтын тавцан дээр тахографын үйлдвэрлэгчээс гаргасан техникийн баримт бичигт заасан зайд шулуун чиглэлд хөдөлгөөн үйлдэх;

6.5. Тахографын тохиргоо гэдэгт:

1) Цагийн бүстэй уялдуулан цагийн тохиргоог хийх;

2) Тухайн тээврийн хэрэгсэлд тогтоосон хурдны хязгаарын заалтыг оруулах;

3) Тахографын (к) тогтмолыг, тээврийн хэрэгслийн үзүүлэлтийн (w) коэффициент, хөтлөгч дугуйн ашигтай тойрог (l), тээврийн хэрэгслийн арлын дугаар болон улсын бүртгэлийн дугаарын шинэчлэлт, эсхүл баталгаажуулалт хийх;

6.6. Тахографын тохиргоог 3 жилд нэг удаа, эсхүл доор дурьдсан аль тохиолдлын дараа хийнэ. Үүнд:

1) Тээврийн хэрэгслийн аль нэг хөтлөгч дугуйн ашигтай тойрог өөрчлөгдсөн;

2) Тээврийн хэрэгслийн үзүүлэлтийн коэффициент өөрчлөгдсөн;

3) Тээврийн хэрэгслийн арлын дугаар, эсхүл улсын бүртгэлийн дугаар өөрчлөгдсөн;

4) Тахографт засвар хийсэн, эсхүл загвар бүтэц өөрчлөгдсөн;

5) Тахографын лац хөндөгдсөн.

6.7. Албан ёсны эрх бүхий этгээдээс бусад этгээд зөвшөөрөлгүйгээр тахографыг нээх, түүний эд ангиудыг салгах, үйл ажиллагааг доголдуулж өөрчлөхөөс сэргийлэх үүднээс тахографыг суурьлуулж дууссаны эцэст лац тавина. Лац нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөн мэдрэгч эд ангийн холбоосууд болон цахилгааны хэлхээ, хиймэл дагуулын GPS системийн мэдээлэл хүлээн авах антенд холбогдох тахографын гаднах холболтууд, түүнчлэн хөдөлгөөн мэдрэгчтэй холбогдох тахографын бусад хэсгүүдэд тавигдана.

6.8. Тахографын засвар болон шинэчлэлтийг үйлдвэрлэгчээс гаргасан техникийн бичиг баримт (тахографын засвар, шинэчлэлтийн гарын авлага)ын дагуу хийнэ. Тахографыг засварласны дараа тахографыг шалгах үйл ажиллагааг энэхүү журамд заасны дагуу хийнэ.

6.9. Үйл ажиллагаа нь доголдсон, эсхүл ашиглалтын хугацаа дууссантай холбоотойгоор тахографыг шинээр солих ажлыг тухайн тахографын үйлдвэрлэгчээс гаргасан техникийн баримт бичгийн дагуу хийж гүйцэтгэнэ.

6.10. Тахографын ашиглагч нар тахографийг ашиглах, үйлчилгээ хийх, засварлах болон ашиглалтаас хасахдаа хувь хүний нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тахографт хадгалагдаж буй мэдээллийн аюулгүй байдлыг хангана.

6.11. Тахографыг ашиглалтаас хасахдаа тахографын үйлдвэрлэгчээс гаргасан техникийн баримт бичигт заасан зааварчилгааг мөрдөнө. Эвдэрсэн, ашиглалтын хугацаа дууссан, мэргэшсэн цахим гарын үсгийн хүчинтэй хугацаа мэргэшсэн гэрчилгээ дууссан тахографыг ашиглалтаас хасахдаа засварын төвүүд нь дараах шаардлагуудыг хангана. Үүнд:

1) Тахографаас мэдээллийг зөөврийн хадгалах төхөөрөмжид хуулж тээврийн хэрэгслийн эзэмшигчид өгнө.

2) Тахографын мэдээллийн блокыг тахографаас салгаж тухайн тээврийн хэрэгслийн эзэмшигчид хадгалуулахаар өгнө. Эдгээр ажил нь холбогдох журмын дагуу хийгдэнэ.

3) Тахографыг ямар шалтгаанаар ашиглалтаас хассан тухай мэдээллийг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-т илгээнэ.

Долоо. Тээврийн хэрэгсэлд суурьлуулсан тахографийг хянах үйл ажиллагаа

7.1. Ачаа болон зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийн жолооч нь тогтоосон ажил, амралтын горимыг зөрчхөөс сэргийлэх зорилгоор засварын төвүүд, тээврийн хэрэгслийн өмчлөгч болон хяналтын байгууллага нь тахографын ажиллагааг хянана.

7.2. Хяналтын явцад дараах шаардлагыг дагаж мөрдөнө:

1) Тахограф суурилуулах тээврийн хэрэгсэл нь энэхүү журмын ... –д заасан шаардлагыг хангасан, тээврийн хэрэгсэлд суурилуулсан тахографын загварын мэдээлэл нь энэхүү журмын-д заасан шаардлага хангасан талаарх мэдээлэл “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын бүртгэлд бүртгэгдсэн байна.

2) Тээврийн хэрэгсэлд суурилуулсан тахограф идэвхжсэн байна;

3) Тахограф нь түгжигдээгүй(блоклогдоогүй) болон өөрчлөлт хийгдээгүй, хэвийн ажиллагаатай байна;

4) Тахографаар бүртгэгдсэн мэдээлэл нь түгжигдээгүй/блоклогдоогүй/ болон засвар ороогүй байна;

5) Тахограф нь ашиглалтын шаардлага хангаж байгааг шалгалтаар баталгаажуулсан гэрчилгээ Стандарт хэмжил зүйн улсын нэгдсэн мэдээллийн санд хадгалагдах ба тахографид хяналт хийсэн тэмдэглэгээ хийгдсэн байх, эсхүл хяналтын тухай гэрчилгээ бичигдсэн байх, эсхүл тахографын гэрчилгээнд бичилт хийгдэж, шалгалт хийсэн хүний гарын үсэг болон тэмдэгээр баталгаажсан байна.

7.3. Тээврийн хэрэгслийг ажилд гарсны дараа жолооч нь ашиглалтын зааврын дагуу тахографын хэвийн ажиллагаанд хяналт тавина.

7.4. Хяналт шалгалтын явцад дараах ажиллагаа хийгдэнэ:

1) Тахографын эд ангиудыг үйлдвэрлэгчээс тавьсан шаардлагын дагуу зөв суурьлуулсан эсэх, тахографыг тээврийн хэрэгсэлд суурьлуулсан засварын ажилтны дугаартай тавьсан лац зэргийг **нүдээр** шалгана;

2) Тээврийн хэрэгсэлд суурьлуулсан тахографын ашиглалтын гарын авлага байгаа эсэх;

3) Тахографаас болон жолоочийн картнаас мэдээлэл хэвлэж байгаа эсэх;

4) Тахографаас болон жолоочийн картнаас мэдээлэл татаж авч болж байгаа эсэх;

5) Тахографт болон жолоочийн картанд засваргүйгээр бүртгэгдсэн мэдээллийг хэвлэгдсэн мэдээлэлтэй тулгах;

6) Дэлгэцэнд мэдээлэл гарч байгаа эсэх;

7) Тээврийн хэрэгсэл жолоодох хугацаа эхлэх болон дуусах үеийн тээврийн хэрэгслийн байршлын мэдээллийг гар аргаар оруулж болж байгаа эсэх

8) Тээврийн хэрэгслийн байршлыг автоматаар тодорхойлж байгаа эсэх;

9) тахограф нь ашиглалтын шаардлага хангаж байгааг шалгалтаар баталгаажуулсан гэрчилгээ Стандарт хэмжил зүйн улсын нэгдсэн мэдээллийн санд хадгалагдах ба тахографид хяналт хийсэн тэмдэглэгээ хийгдсэн байх, эсхүл хяналтын тухай гэрчилгээ бичигдсэн байх, эсхүл тахографын гэрчилгээнд бичилт хийгдэж, шалгалт хийсэн хүний гарын үсэг болон тэмдэгээр баталгаажсан эсэх.